



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 442

Улаанбаатар хот

Г Хөтөлбөр батлах тухай Г

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.6 дахь заалтыг үндэслэн, Монгол улсын Засгийн газрын 2014 оны 34 дүгээр тогтоол, "Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

- Хорт хавдраас сэргийлэх, хянах /2015-2020/ дэд хөтөлбрийг хавсралтаар баталсугай.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я. Буянжаргал/, хэрэгжилтэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв болон олон улсын төсөл хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгах замаар санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Д.Төмөрбаатар/-т тус тус үүрэг болгосугай.
- Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А. Эрдэнэтuya/-д үүрэг болгосугай.



Эрүүл мэндийн сайдын
2014 оны 12 сарын 02 өрдийн
412 дугаар тушаалын хавсралт

ХОРТ ХАВДРААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ДЭД ХӨТӨЛБӨР /2015-2020 ОН/

Нэг. Үндэслэл

Хорт хавдрын өвчлөлийн өнөөгийн байдал

Дэлхий дахинаа жилд 14,1 сая хүн шинээр хорт хавдраар өвчилж, 8,2 сая хүн хорт хавдрын улмаас нас барж байна. Хорт хавдрын өвчлөл, нас барагтын талаас илүү хувь нь хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнуудад бүртгэгдсэн байна¹. Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, хянах оновчтой арга хэмжээ цаг алдалгүй авч хэрэгжүүлэхгүй бол 2025 он гэхэд жил бүр 19,6 сая хүн шинээр хорт хавдраар өвчлөх тооцоолол гарч байна².

Манай орны хувьд ч хорт хавдрын өвчлөл жилээс жилд өсөх хандлагатай байна. 2003 оны байдлаар хорт хавдрын 3511 шинэ тохиолдол, 2729 нас барагт бүртгэгдэж байсан бол 2013 онд 5255 шинэ тохиолдол, 3660 нас барагт болж өссөн байна. 2003 онд 100000 хүн амд ноогдох хорт хавдрын өвчлөлийн түвшин 142, нас барагт 110 байсан бол 2013 оны байдлаар нийт хорт хавдрын өвчлөлийн түвшин 100 000 хүн амд 186 тохиолдол ногдож байна. Хорт хавдар нь хүн амын нас барагтын 22 хувийг эзэлж, нас барагтын тэргүүлэх шалтгааны нэг болж, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болоод байна.

Хорт хавдраас сэргийлэх, хянах бодлогын өнөөгийн байдал

Монгол улс “Халдварт бус өвчинөөс сэргийлэх, хянах асуудлаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тунхаглал”, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын “Халдварт бус өвчинөөс сэргийлэх дэлхий дахини үйл ажиллагааны төлөвлөгөө”-тэй уялдуулан Хорт хавдраас, сэргийлэх, хянах бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн хэрэгжүүлж ирсэн билээ.

Монгол улс 2008-2013 онд “Халдварт бус өвчинөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр 2008-2013”-ийн хүрээнд “Хорт хавдраас сэргийлэх хянах, сэргийлэх дэд хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлсэн.

Одоогоор Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчинөөс сэргийлэх, хянах үндэсний хоёрдахь хөтөлбөр 2014-2021”-ийн дор хорт хавdraас сэргийлэх, хянах ажил бодлогын түвшинд зохицуулагдаж байна.

¹Globocan 2012, IARC

²Latest world cancer statistics, IARC, WHO, 2013

Тус хөтөлбөрийн хүрээнд “Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх стратеги 2014-2018-ийг” боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн нь хорт хавдраас сэргийлэх, хянах ажилд томоохон хувь нэмэр оруулсан ажил болсон.

Хорт хавдраас сэргийлэх асуудал дараах хууль, бодлого, хөтөлбөрт тусгагдан хэрэгжиж байна. Үүнд: Дархлаажуулалтын хууль, Хүнсний тухай хууль, Архидан согтуурахаас сэргийлэх, хянах хууль, Тамхины хяналтын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх бодлого, Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол, Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги, Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, Эрүүл мэндийн боловсролын талаар баримтлах стратеги, Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үндэсний хөтөлбөр, Хорт хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, Туяа эмчилгээг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг болно.

2009-2013 оны хугацаанд Монголын мянганы сорилтын сан (ММСС)-гийн санхүүжилтээр халдварт бус өвчин түүний дотор зарим хорт хавдраас³ сэргийлэхэд чиглэсэн төслийг амжилттай хэрэгжүүлсэн билээ.

Түүнчлэн Монгол улс Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА)-ийн ПАКТ⁴ хөтөлбөрийн жишиг наймдахь орноор сонгогдсон нь хорт хавдрын оношилгоо, эмчилгээ, ялангуяа туяа эмчилгээний цаашдын хөгжилд нь багагүй хувь нэмрийг оруулж байна.

Мөн аймаг, дүүргийн түвшинд хорт хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааг сайжруулах талаар Эрүүл мэндийн сайдын 2010 оны 292 дугаар тушаал батлагдан хэрэгжиж байгаа нь хорт хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах, хорт хавдрын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хөгжүүлэхэд түлхэц болж байна.

Хэдийгээр “Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр 2008-2013”-ийг амжилттай хэрэгжиж тодорхой үр дүнд хүрсэн боловч хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээний зөвлөмжид үндэслэн 2015-2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах зайлшгүй шаардлагатай байна.

Хорт хавдрын урьдчилан сэргийлэлт

Хорт хавдрын нас баралтын 40 гаруй хувийг сэргийлэх боломжтой бөгөөд хорт хавдрын урьдчилан сэргийлэлт нь хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөрийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм⁵.

Архи, тамхины хэрэглээ, зохисгүй хооллолт буюу жимс, жимсгэнэ, хүнсний ногоо хангалтгүй хэрэглэх, хөдөлгөөний хомсдол, илүүдэл жин, таргалалт, мөн хэт ягаан туяа, цацраг туяа гэх мэт физикийн хүчин зүйлс, бензопирен, формальдегид, афлатоксин, асбестоз мэт химиийн хүчин зүйлс, вирус, бактери, паразит зэрэг

³Умайн хүзүү, хөхний хорт хавдар

⁴Programme of Action for Cancer Therapy

⁵Cancer Control. Knowledge into Action. WHO Guide for Effective Programmes

биологийн хүчин зүйлс хорт хавдар үүсэхэд нөлөөлдөг болох нь судалгаагаар батлагдсан⁶.

Манай орны хүн амын дунд хорт хавдар үүсгэдэг эрсдэлт хүчин зүйлсийн тархалт өндөр хэвээр байна. Тухайлбал 2013 оны судалгаагаар нийт хүн амын 27.1%, үүнээс эрэгтэйчүүдийн 49.1%, эмэгтэйчүүдийн 5.3% тамхи татдаг бөгөөд тамхи хэрэглэгчдийн 91.7 % нь тамхийг өдөр бүр тогтмол татдаг байна. 2 хүн тутмын 1 нь (42.9%) гэрийн дотоод орчинд, 3 хүн тутмын 1 нь (35.6%) ажлын байрандаа дам тамхидалтад өртөж байна.

Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын шаталсан судалгаагаар хүн амын 38.3% нь сүүлийн 1 сард архи согтууруулах ундаа хэрэглэсэн байна. Сүүлийн 1 сард архийг 6 буюу түүнээс дээш стандарт уултаар хэтрүүлэн уусан тохиолдол нийт хүн амын 23.5% байгаа нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад өссөн, эрсдэл бүхий зан үйл хэвээр байна.

Монгол хүн хоногт дунджаар 0.4 нэгж жимс, 1,0 нэгж хүнсний ногоо хэрэглэж байгаа нь ДЭМБ-ын зөвлөмж болгож буй хэмжээнээс 3.6 нэгжээр доогуур байна. Мөн хүн амын 96.4% нь хоногт 5 нэгжээс бага жимс, хүнсний ногоо хэрэглэж байгаа бөгөөд хөдөөгийн хүн амын жимс, хүнсний ногооны хэрэглээ нь хотын хүн амынхаас 2 дахин бага байна.

Судалгаагаар нийт хүн амын 23.2%-ийг хөдөлгөөний хомсдлын эрсдэл өндөр хүн ам эзэлж байгаа бөгөөд Улаанбаатар хотын 4 хүн тутмын 1 нь энэхүү эрсдэлд өртөж байна. Хөдөлгөөний хомсдолд хөдөө амьдардаг эрэгтэйчүүдээс хотод амьдардаг эрэгтэйчүүд 4 дахин, харин эмэгтэйчүүд нь 2 дахин илүү орох эрсдэлтэй байна. Хүн амын идэвхтэй хөдөлгөөнд зарцуулах хоногийн голч хугацааг тооцоход ажлын байранд 105.7 минут байгаа нь өмнөх судалгааны дүнгээс даруй 2 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Судалгаанд дурдсанаар хүн амын биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ 25.9 кг/м² гарсан бөгөөд үүнээс эрэгтэйчүүдийнх 25.3кг/м², эмэгтэйчүүдийнх 26.6 кг/м² байна. Нийт хүн амын БЖИ-ийн эрсдлийн үнэлгээгээр 34.8% нь илүүдэл жинтэй бөгөөд үүнээс 19.7% таргалалттай⁷ гэсэн дүгнэлт гарч байна.

Тоон үзүүлэлтээс харахад Монгол улсын нийт хүн амын дунд элэгний Ц вирусийн халдвар 15.6%-ийн тархалттай байгаа⁸- бөгөөд элэгний хорт хавдрын шалтгааны 46%-ийг нь элэгний Ц вирус, 35%-ийг нь элэгний Б вирус, 14%-ийг нь элэгний Б болон Ц вирусийн хавсарсан халдвар эзэлдэг байна⁹.

Иймд дээр дурдсан хорт хавдарт өвчин үүсгэх эрсдэлт хүчин зүйлсээс хүн амыг урьдчилан сэргийлэх асуудал нь “Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр”-т томоохон байр суурийг эзлэх болж байна.

⁶Cancer Control. Knowledge into Action. WHO Guide for Effective Programmes

⁷Эрсдэлт хүчин зйлсийн шаталсан судалгаа, 2013

⁸О.Баатархүү нарын Монгол улсын хүн амын дундах элэгний В, С вирусийн халдварын үндэсний судалгаа, 2008, Liver international, 2008

⁹О.Баатархүү нарын Монгол улсын элэгний хорт хавдрын эмнэлзүйн явц болон прогнозын олон төвт судалгаа, 2012, Hepatology international, 2012

Хорт хавдрын эрт илрүүлэлт

Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөрийн хүрээнд үр дүнтэй эрт илрүүлэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хорт хавдрын гуравны нэгийг эрт илрүүлж, эмчлэх улмаар хорт хавдраар өвчлөгсдийн амьдрах хугацааг уртасгах боломжтой¹⁰.

Манай оронд жилд 5000 гаруй хорт хавдар бүртгэгдэж байгаагийн 75% нь хожуу буюу хорт хавдрын өвчний 3,4-р шатандаа оношлогдож байна¹¹.

ММСС-ийн Эрүүл мэндийн төслийн дэмжлэгтэйгээр 2012 оноос хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгийн хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн. Энэхүү илрүүлэг үзлэгээр илэрсэн хорт хавдрын 51.1% нь эрт үедээ оношлогдсон нь умайн хүзүүний хорт хавдрыг урьтал болон эрт үед нь илрүүлэх улмаар төгс эмчлэх боломжтойг илтгэж байна. Мөн хөхний хорт хавдрын илрүүлэг үзлэгийн дүнгээс харахад хөхний хорт хавдрын 15.0% нь эрт үедээ оношлогдсон байна.

Монгол улс 2014 онд элэгний хорт хавдрын эрт илрүүлэх стратегийн хүрээнд элэгний хорт хавдрыг эрт үе шатанд нь илрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдан гарч хэрэгжүүлж эхлээд байна.

2011 оноос эхлэн ХСҮТ, ХААН банк, МҮОНРТ-тэй хамтран “Хавдрын эсрэг үндэсний аян”-ыг зохион байгуулж ирсэн бөгөөд энэхүү аяны хүрээнд эрсдэлт бүлгийн хүн амыг хавдрын нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, оношилгоонд шинжилгээнд хамруулж хорт хавдрыг эрт илрүүлэхийн зэрэгцээ эрт илрүүлэлт, урьдчилан сэргийлэлтийн талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж ирсэн билээ.

Түүнчлэн 2004 онд ХСҮТ-ээр үйлчлүүлсэн иргэдийн тоог 2012 оны тухайн үзүүлэлттэй харьцуулахад 20 гаруй хувиар өссөн байгаа нь хүн амын эрүүл мэндийн боловсрол дээшилж, хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт хамрагдах сонирхол нэмэгдсэнтэй холбоотой юм.

Иймд хорт хавдрын эрт илрүүлэлтийн хөтөлбөрийг өргөжүүлж, ходоод, улаан хоолой, бүдүүн, шулуун гэдэсний хавдар зэрэг хүн амын дунд зонхилон тохиолдож буй эрт илрүүлэх боломжтой байрлалын хавдрыг эрт илрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ тулгарч байна. Түүнчлэн эрт илрүүлэгийн талаар нийт хүн ам болон эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, ухуулга, нөлөөллийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах нь тус хөтөлбөрийн нэг чухал зорилт болж байна.

Хорт хавдрын оношилгоо, эмчилгээ

Хорт хавдрыг эрт үед нь оношилсноор хорт хавдрын өвчлөлийн гуравны нэгийг эмчлэх боломжтой. Хорт хавдрын оношилгоонд эмнэлзүйн үзлэг, лабораторийн болон дурс оношилгооны шинжилгээ, эд, эс зүйн шинжилгээ зэрэг олон төрлийн аргыг ашигладаг. Мөн хорт хавдрын эмчилгээнд мэс засал, туяа, хими, гормон эмчилгээний зэрэгцээ сэтгэлзүй, хоол зүй, нийгмийн тусламж, сэргээн засах зэрэг дэмжих тусламж, үйлчилгээ багтана.

¹⁰Cancer Control. Knowledge into Action. WHO Guide for Effective Programmes. Early Detection

¹¹Хорт хавдрын үзүүлэлт, 2008-2012 он

Энэхүү цогц тусламж, үйлчилгээ нь хорт хавдрыг оношлох, эмчлэх, өвчтний амьдрах хугацааг уртасгах болон амьдралын чанарыг сайжруулах зорилготой¹².

Хорт хавдрын тусламж үйлчилгээний чанарын судалгааны дүнгээс хараад хорт хавдрын улмаас эмнэлэгт хандаж буй нийт үйлчлүүлэгчдийн дийлэнх нь (72.7хувь) өрх, сумын эрүүл мэндийн төвийг алгасан үйлчлүүлсэн, эмч нарын 60-70 хувь нь өвчтөнд илэрч байгаа зовиур шаналгааг бүрэн гүйцэд тодруулан асуугаагүй гэсэн дүгнэлт гарч байна. Түүнчлэн хорт хавдрын хожуу оношлогооны 45.2 хувь нь хавдрын оношлуур дутмагаас, 32.3 хувь нь нарийн мэргэжлийн тоног төхөөрөмжгүйн улмаас, 16.1 хувь нь өөрийн боломжгүйгээс, 12.9 хувь нь эмч, сувилагч нарын харилцааны доголдол нөлөөлдөг гэж үзсэн байна¹³. Мөн эмч нарын 80-аас дээш хувь нь хорт хавдар өвчлөл гэж сэжиглэж байгаа тохиолдолд шууд III шатлал буюу Хавдар судлалын үндэсний төв рүү илгээдэг байна.

Дээрх судалгааны дүнгээс аймаг дүүргийн түвшинд хорт хавдрын тусламж үйлчилгээний зохон байгуулалт оновчгүй, тусламж үйлчилгээ үзүүлдэг хүний нөөцийн чадавхи сул, тоног төхөөрөмж ч хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлгийн бүтцэд хавдрын тасгийг бий болгож, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, хорт хавдрын бүртгэл мэдээллийг чанаржуулах, хавдрын эрсдэлтэй зан үйлийг өөрчлөх харилцааг явуулах, энэ чиглэлээр сүм, өрхийн эмнэлгүүдэд арга зүйн тусламж үзүүлэх чадварыг бэхжүүлэх асуудал тулгамдсаар байна

¹⁴

Хорт хавдрын лавлагаа төв болох ХСҮТ-ийн хувьд оношилгооны чадамжийг эдзүйн болон дүрс оношилгоо, лабораторийн чиглэлээр бэхжүүлэх, зарим шинэ технологийг нэвтрүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах зайлшгүй шаардлагатай байна. Мөн эмчилгээний чадамжийг дурангийн болон эрхтэн хадгалах, нөхөн сэргээх мэс заслын чиглэлээр хөгжүүлэх, элэг шилжүүлэн суулгах технологийг бий болгох асуудал тулгамдаж байна. Цаашилбал туяа эмчилгээнд шугаман хурдасгуурыг, мөн гурван хэмжээст төлөвлөлтийг зайн болон дотуур туяа эмчилгээнд нэвтрүүлэх, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах ажил хийгдэх хэрэгтэй. Хими эмчилгээний орчин үеийн эм, бэлдмэлийн төрлийг олшуулах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, хими эмчилгээний аюулгүй орчинг сайжруулах бодит хэрэгцээ байна.

Хорт хавдрын оношилгоо, эмчилгээний үр дүнтэй бодлогыг салбар дундын хамтын ажиллагаа, эрүүл мэндийн салбарын нэгдмэл цогц үйл ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ

Хорт хавдрын шинэ тохиолдлын 75 гаруй хувь нь өвчний хожуу үе шатандаа оношлогдож байна. Жилд 3000 гаруй хүн хорт хавдрын улмаас нас барж байгаагийн

¹² WHO

¹³ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, үнэлгээний тайлан II, 2013

¹⁴ Хорт хавдраас сэргийлэх, хянах стратеги төлөвлөгөө, 2011-2021

60-аас илүү хувь нь анх оношлогдсон тухайн жилдээ нас барж байна¹⁵. Хавдар судалын үндэсний төвийн хөнгөвчлөх эмчилгээний тасагт 2003 онд 511 хүн хэвтэн эмчлүүлж байсан бол 2013 онд 858 хүн хэвтэн эмчлүүлж 286 хүн нас барсан. Ийнхүү хөнгөвчлөх эмчилгээ шаардлагатай өвчтний тоо жилээс жилд өсөж байхад улсын хэмжээнд хөнгөвчлөх эмчилгээний 48 ор, Улаанбаатар хотын дүүргийн эмнэлгүүдэд 8 ор ажиллаж байгаа нь хөнгөвчлөх тусlamж, үйлчилгээ үзүүлэх эмч, мэргэжилтэн, хэвтэн эмчлүүлэх орны хэрэгцээ шаардлага мөн нэмэгдэж байгааг харуулж байна.

Иймд хөнгөвчлөх тусlamж, үйлчилгээний чанар, хүrtээмжийг сайжруулахад анхан ба хоёрдах шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад хөнгөвчлөх тусlamж, үйлчилгээний мэргэжилтнийг бэлтгэх, арга зүйгээр хангах ажлыг сайжруулах шаардлагатай байна.

Түүнчлэн өвчтөн түүний гэр бүл, асран хамгаалагчийг сургах тэдэнд зориулсан гарын авлага бэлтгэн хүргэх зэрэг олон нийтэд түшиглэсэн хөнгөвчлөх эмчилгээ үйлчилгээ хөгжүүлэх нь хөнгөвчлөх тусlamж, үйлчилгээний хүrtээмжийг нэмэгдүүлэх, амьдралын чанарыг сайжруулахад ихээхэн ач холбогдолтой.

Хорт хавдрын бүртгэл мэдээлэл, судалгаа

Шинжлэх ухааны дэвшилтэт технологид суурилсан хорт хавдраас сэргийлэх, хянах бодлого, хөтөлбөрийг төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор хорт хавдрын тэргүүлэх чиглэлийн дагуу судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэх, санхүүжүүлэлтийн оновчтой арга замыг бүрдүүлэх, судлаачдыг бэлтгэж, чадавхийг бэхжүүлэх ажил чухал юм. Ялангуяа хорт хавдрын судалгаа, шинжилгээний ажилд молекул биологи, генетикийн судалгааг хөгжүүлэх нь зүй ёсны юм.

Түүнчлэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх, төлөвлөхөд хорт хавдрын судалгаа, тоо бүртгэл, мэдээлэл, тандалтын тогтолцооны мэдээллийг оновчтой ашиглах хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Хүн амд суурилсан хорт хавдрын бүртгэл мэдээлэл, тандалтын тогтолцоог бэхжүүлэх, мөн хорт хавдрын үндэсний мэдээний санд гуравдах шатлалын төв, эмнэлгүүд болон эмгэг судлалын төвийн мэдээллийг нэгтгэж, бүртгэл мэдээллийн чанарыг сайжруулах хэрэгцээ байна.

Дээр дурдсан асуудлуудаар Монгол улсад хорт хавдарын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, хорт хавдрын тусlamж үйлчилгээний чанар, хүrtээмжийг сайжруулах, судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, бүртгэл мэдээллийг сайжруулах чиглэлээр нотолгоонд тулгуурласан бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Хоёр. Хөтөлбөрийн алсын хараа, зорилго, зорилт

Алсын хараа

- Хорт хавдрын өвчлөлийн гуравны нэгзээс сэргийлэх

¹⁵Хорт хавдрын үзүүлэлт, 2008-2012

- Бүх хорт хавдрын өвчлөлийн гуравны нэгийг эрт илрүүлсний үндсэнд эмчлэх
- Эмчлэгдэх боломжгүй, хожуу үе шатандаа буй хорт хавдартай хүмүүсийн гуравны хоёрыг хөнгөвчлөх тусlamж үйлчилгээнд хамруулах

Зорилго

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, хөнгөвчлөх тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нотолгоонд сууриссан бодлогыг хэрэгжүүлэх замаар хорт хавдрын эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх, амьдрах хугацааг уртасгах, амьдралын чанарыг сайжруулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Зорилтууд

Зорилт 1. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлс (архи, тамхины хэрэглээ, зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, таргалалт, орчны болон ажлын байрны хүчин зүйлс гэх мэт)-ийн тархалтыг бууруулах, хүний хөхөнцөр вирус болон В гепатитийн вирусийн дархлаажуулалтыг амжилттай хэрэгжүүлэх замаар хорт хавдраас урьдчилан сэргийлнэ.

Зорилт 2. Хорт хавдрын эрт илрүүлэгийн хөтөлбөр, стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хавдрыг эрт үе шатанд нь илрүүлж, эмчилийн.

Зорилт 3. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний бүх шатлалд хавдрын тусlamж, үйлчилгээний чадавхийг сайжруулах, оношилгоо, эмчилгээний шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хорт хавдрыг эрт үед нь оношилж, хорт хавдраар өвчлөгсдийг хамгийн үр дүнтэй тусlamж, үйлчилгээнд хамруулж, амьдрах хугацааг уртасгана.

Зорилт 4. Хөнгөвчлөх тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний бүх шатлалд сайжруулах, олон нийтэд түшиглэсэн тусlamж үйлчилгээг хөгжүүлсэнээр төгс эмчлэх боломжгүй хожуу үедээ илэрсэн хавдартай хүмүүсийг хөнгөвчлөх тусlamж, үйлчилгээнд хамруулж, амьдралын чанарыг сайжруулна.

Зорилт 5. Хавдрын тархвар зүйн судалгааг хөгжүүлэх, эмнэлзүйн судалгааны ажлыг өргөжүүлэх, хорт хавдрын урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээний практикт судалгаа, шинжилгээний хамгийн сүүлийн үеийн үр дүн, сайн туршлагуудыг нэвтрүүлнэ.

Зорилт 6. Хүн амд сууриссан хорт хавдрын бүртгэл, тандалтын тогтолцоог бэхжүүлнэ.

Зорилт 1 Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлс (архи, тамхины хэрэглээ, зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, таргалалт, орчны болон ажлын байрны хүчин зүйлс гэх мэт)-ийн тархалтыг бууруулах, хүний хөхөнцөр вирус болон В	Хүрэх үр дүн Халдварт бус, халдвартын, орчны болон ажлын байрны нөхцөлтэй холбоотой хорт хавдар үүсэхэд нөлөөлдөг эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, хянах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.
--	---

гепатитийн вирусийн дархлаажуулалтыг амжилттай хэрэгжүүлэх замаар хорт хавдраас урьдчилан сэргийлнэ.

1.1 Халдвартын хүчин зүйлс: Анхдагч урьдчилан сэргийлэлтээр сэргийлж болох халдвартын эсрэг дархлаажуулалтад хүн амыг бүрэн хамруулах ажлыг эрчимжүүнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

- Умайн хүзүүний өмөн үүсэхэд нөлөөлдөг хүний хөхөнцөр вирусийн халдвартын эсрэг вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлэх асуудлыг судлах
- Вируст гепатиттэй тэмцэх үндэсний стратеги, элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх стратегийн хэрэгжилтийг хангах
- Вируст гепатит B, C-ийн халдвартын өвөрмөц эмчилгээний асуудлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх ажлыг судлах
- Халдвараас шалтгаантай үүсдэг хорт хавдрын хамаарлыг судлах судалгааны ажлыг хийсний үндсэн дээр халдвараас сэргийлэх талаар бодлогыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх

1.2

Халдвартын бус хүчин зүйлс: Архи, тамхины хэрэглээ, зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, таргалалтыг бууруулахад нөлөөлөх үр дүнтэй урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

- Тамхины хяналтын хууль, Архидан согтуурахтай тэмцэх хууль, Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги зэрэг бодлогын хэрэгжилттэй нягт уялдуулан хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлыг өргөн цар хүрээтэй хэрэгжүүлэх
- Хавдрын эрсдэлт хүчин зүйлс, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны стратегийг нийт хүн ам, эмнэлгийн мэргэжилтнүүд, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт зориулан тусгайлан боловсруулж, оновчтой зохион байгуулж хэрэгжүүлэх
- Хавдрын эрсдэлт хүчин зүйлс, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилд иргэд, хувь хүн, хамт олон, төр, төрийн бус, олон улсын байгууллагын болон хувийн хэвшилийн оролцоог нэмэгдүүлэх
- Орчны болон мэргэжлийн хортой нөлөөлөл, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт түүний ач холбогдолын талаар аж ахуйн нэгж, байгууллагын хамт олон, иргэд, олон нийтэд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах
- Байгууллагуудад халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг хянаж бууруулахад дэмжлэг болох орчин (чийрэгжүүлэлтийн заал тохижуулах, архи, тамхины хор хөнөөлийн талаар мэдээлэл, сургалт хийх, ажиллагсдыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах гэх мэт) бүрдүүлэх

1.3 Орчны болон ажлын байрны нөхцөлтэй холбоотой хүчин зүйлс: Ажлын байрны болон мэргэжлийн таагүй нөлөөллөөс үүдэлтэй хорт хавдрын өвчлөл тодорхой бүлэг хүн амын дунд тохиолдох эрсдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

1. Ажлын байран дах хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн нөлөө, үр дагавар, сэргийлэх талаар сургалтын хөтөлбөр боловсруулах
2. Ажлын байран дах хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн нөлөө, үр дагавар, сэргийлэх талаар сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт явуулж, хөдөлмөр хамгаалалтын нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн ухуулга, нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх
3. Хорт хавдар үүсэхэд нөлөөлдөг химиийн (төрөл бүрийн будаг, бензилперин, афлотоксин, формальдегид) болон физикийн хүчин зүйлс (хэт ягаан туяа, цацраг идэвхит туяа гэх)-ээс сэргийлэх талаар сургалт, сурталчилгааны ажлыг холбогдох байгууллагуудын оролцоотой зохион байгуулах

Зорилт 2.

Хорт хавдрын эрт илрүүлэгийн хөтөлбөр, стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хавдрыг эрт үе шатанд нь илрүүлж, эмчилнэ.

Хүрэх үр дүн

Хорт хавдрын эрт илрүүлгийн тогтолцоо бэхжиж, хүн амын хүн амын эрүүл мэндийн боловсрол дээшилсэний үр дүнд эрт илрүүлгийн үзлэгийн хувь нэмэгдэж, эрт үедээ илэрсэн хорт хавдрын өвчлөлийн хувь өссөн байна.

3.1 Хөх умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх

Үйл ажиллагааны чиглэл:

- Хорт хавдрын эрт илрүүлгийн бүртгэл мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгож эргэн дуудах тогтолцооны програм хангамжийн хэрэглээг сайжруулах
- Олон улсын байгууллагуудтай эрт илрүүлгийн чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Орон нутгийн засаг дарга, эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг хөх, умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэг үзлэгийг явуулахад шаардлагатай хүний нөөц, эм урвалж, тоног төхөөрөмжөөр тасралтгүй хангаж ажиллах
- Хорт хавдрыг эрт үе шатанд оношилох чадамжийг эрүүл мэндийн байгууллагын бүх шатлалд сайжруулах
- Эрт илрүүлэгийн хөтөлбөрийн хяналт үнэлгээний ажлыг тогтмолжуулах
- Эрт илрүүлэгийн үзлэг, шинжилгээний ач холбогдолын талаар сургалт, сурталчилгааны ажлыг хүн амын дунд өргөн хүрээтэй зохион байгуулах
- Хувь хүн, байгууллага, хамт олны эрт илрүүлэг үзлэгт хамрагдах ажлыг дэмжих

2.2 Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэх

Үйл ажиллагааны чиглэл:

- Элэгний хорт хавдрын эрт илрүүлэгийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох
- Орон нутгийн засаг дарга, эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг элэгний хорт хавдрын илрүүлэг үзлэгийг явуулахад шаардлагатай хүний нөөц, эм урвалж, тоног төхөөрөмжөөр тасралтгүй хангаж ажиллах
- Хувь хүн, байгууллага, хамт олны эрт илрүүлэг үзлэгт өргөн хамрагдах ажлыг дэмжих
- Элэгний хорт хавдрын илрүүлэг үзлэгт хамрагдах, эрт үеийн шинж тэмдгийг мэдэж эмчид хандах талаар хүн амд мэдлэг олгох
- Элэгний хорт хавдар эрт илрүүлэх стратегийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх орон нутгийн хяналт үнэлгээг эрчимжүүлэх
- Элэгний хорт хавдрыг эрт үе шатанд нь илрүүлэх оношилгооны чадамжийг эрүүл мэндийн байгууллагын бүх шатлалд сайжруулах
- Эрт илрүүлэг үзлэгийг гардан хийх эмч нарын ажлын ачааллыг тооцох, тэднийг тасралтгүй сургаж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх
- Гепатит В, С вирусийн эмчилгээний зардлыг ЭМДС-аас санхүүжүүлэх асуудлыг судлах

2.3 Хүн амын дунд зонхилон тохиолддог бүдүүн шулуун гэдэс, ходоод, улаан хоолойн хорт хавдрын эрт илрүүлэгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэл, тооцоо, судалгаа хийж, хөтөлбөрийг туршилтын журмаар эхлүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

- Ходоод, удаан хоолой бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэгийн хөтөлбөр хэрэгжүүлэх үндэслэл, тооцоо, судалгаа хийж
- Өвчлөл, нас бааралтын хэтийн хандлага, оношилгооны чадамж зэргийг харгалзан үзэж эрт илрүүлэгийн хөтөлбөрийг тодорхой аймаг, дүүргийг сонгон туршилтаар эхлүүлэх
- Хүн амын дунд дээрх хорт хавдраас сэргийлэхэд эрт илрүүлэг үзлэгт хамрагдах талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах
- Эдгээр хорт хавдрын эрт илрүүлэгийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай хүний болон тоног төхөөрөмжийн нөөцийн судалгаа хийж

Зорилт 3.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх шатлалд хавдрын тусламж, үйлчилгээний чадавхийг сайжруулах, оношилгоо, эмчилгээний шинэ дэвшилтэт техник, технологи

Хүрэх үр дүн

Хорт хавдрын оношлогоо, эмчилгээний орчин үеийн үр дүнтэй шинэ аргыг нэвтрүүлсэнээр, одоо байгаа оношлогоо, эмчилгээний чадамж олон улсын жишигт хүрч, хүртээмж нэмэгдсэн байна.

нэвтрүүлж, хорт хавдрыг эрт үед нь оношилж, хорт хавдраар өвчлөгсдийг хамгийн үр дүнтэй тусlamж, үйлчилгээнд хамруулж, амьдрах хугацааг уртасгана.

3.1 Хорт хавдрын оношилгооны чадавхийг эрүүл мэндийн салбарын бүх шатлалд сайжруулна.

Үйл ажиллагааны чиглэл:

- Хорт хавдрын оношилгооны лавлагаа лаборатори байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах
- Молекул генетикийн лабораторийг ХСҮТ-д байгуулж хорт хавдрын оношлогоо, судлагааны чадавхийг нэмэгдүүлэх
- Хорт хавдрын дүрслэл оношилгоонд техник технологийн шинэчлэлийг үргэлжлүүлэн хийж, КТГ, цахилгаан соронзон томографи, позитрон-эмиссион томографи нэвтрүүлэх
- Эс, эдзүйн шинжилгээний чадавхийг бэхжүүлж, иммуногистохими, хагалгааны явцын экспресс шинжилгээ зэрэг шинэ аргыг нэвтрүүлэх
- Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эс, эдзүйн шинжилгээний чадавхийг бэхжүүлэх
- Сум, өрхийн эрүүл мэндийн төв (анхан шатны тусlamж үйлчилгээ)-ийн түвшинд хавдрын урьдал өвчнийг илрүүлэх, шилжүүлэх, хянах, хөнгөвчлөх эмчилгээний чадамжийг дээшлүүлэх
- Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын оношилгооны чадамж (хүний нөөц болон тоног төхөөрөмж)-ийг сайжруулах

3.2 Хорт хавдрын тусlamж, үйлчилгээг аймаг, дүүргийн бэхжүүлж, төвлөрлийг сааруулах, бүх шатлалд тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

- Аймаг, дүүргийн эмнэлэгт хавдрын хими, хөнгөвчлөх эмчилгээ, хавдрын мэс заслын эмчилгээний тусlamж үзүүлэх 15-20 ортой хавдрын тасаг байгуулах, хавдар судлаач эмч, сувилагч, хөнгөвчлөх эмчилгээний эмч, сувилагч, хавдар бүртгэгчийг орон тоогоор ажиллуулах
- Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад хими эмчилгээ хийх аюулгүй ажиллагааны нөхцлийг хангаж, шаардлагатай химиин эм бэлдмэлээр тасралтгүй хангах
- Хорт хавдрын оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамжийг шинэчлэн боловсруулж, мөрдөх
- Өдрийн хими эмчилгээ хийх, хавдартай өөчтөнд гэрээр хөнгөвчлөх тусlamж үзүүлэх
- Хавдрын дэмжих үйлчилгээ болох сэтгэл засал, хоол эмчилгээ, нийгмийн

тусламж үйлчилгээ болон нөхөн сэргээх эмчилгээг бэхжүүлэх

- Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт ажиллах хавдрын төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдийг тасралтгүй давтан сургах, шинээр нэвтэрч буй технологид ажиллах өндөр мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдийг бэлтгэх
- XCYT ийн эмчилгээ, үйлчилгээний цахим сүлжээний тогтолцоог бэхжүүлж, PACS-ийг бүрэн нэвтрүүлж, олон улсын жишигт нийцүүлэх,
- Шинээр нэвтрүүлсэн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн аюулгүй, найдвартай ажиллагаа, засвар үйлчилгээг хангах чадавх бүхий баг бүрдүүлэх
- Лавлагаа тусламжид шилжүүлэх оновчтой тогтолцоог бүрдүүлэх
- Хорт хавдрын оношилгоо, эмчилгээ болон эмч, мэргэжилтнийг сургахад телемедицинийг өргөн ашиглах
- Хорт хавдрын зарим төрлийн тусламж, үйлчилгээ (өндөр өртөгтэй хими эмчилгээний эм, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ, дүрс оношилгоо, ангиографи, мэс заслын эмчилгээний багаж, хэрэгсэл өдрийн эмчилгээ,) -ний зардлыг эрүүл мэндийн даатгалд хамруулах асуудлыг судлах

Хүрэх үр дүн: Хорт хавдрын эмчилгээний орчин үеийн үр дүнтэй шинэ арга, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, аймаг, дүүргийн оношилгоо, эмчилгээний чадамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.4 Туяа эмчилгээ

Шугаман хурдаасгуур аппарат суурилуулж, үүнд тулгуурласан туяа эмчилгээний орчин үеийн, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл

- Зайн туяа эмчилгээг 4 хэмжээст технологид, дотуур туяа эмчилгээг 3 хэмжээст технологид шилжүүлэх
- Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны ОУАЭА бусад холбогдох дотоодын болон олон улсын байгууллагын стандартыг мөрдөх
- Туяа эмчилгээний чанарын хяналтыг орчин үеийн түвшинд хүргэх
- Зонхилон тохиолдох хавдрын туяа эмчилгээ, түүний хүндрэл, үр дүнд судалгаа хийж цаашдын үйл ажиллагааны чиглэл тодорхойлон үйл ажиллагаандаа ашиглах
- Туяаны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг мэргэжлийн инженер, техникчдийн баг ажиллаж, хуваарийн дагуу тогтмол хийх

Хүрэх үр дүн: Туяа эмчилгээний хүртээмж нэмэгдэж, эмчилгээний чанарын баталгаа сайжирч өвчтний амьдрах хугацаа уртсан, амьдралын чанар дээшилнэ. Туяаны тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа хангагдана.

3.5 Хими эмчилгээ

Хими эмчилгээнд орчин үеийн шинэ эм, бэлдмэлийг эмчилгээнд бүрэн нэвтрүүлж, хими эмчилгээний аюулгүй орчныг бэхжүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл

- Аймаг, дүүргийн түвшинд хими эмчилгээний ламинар боксыг нэвтрүүлж аюулгүй ажиллагааг хангах
- Хорт хавдрын үеийн бай эмчилгээг шинээр нэвтрүүлэх, боловсон хүчиний чадавхийг дээшлүүлэх
- Өндөр өртөгтэй хими эмчилгээний орчин үеийн эмүүд болон өдрийн хими эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх
- Хими эмчилгээнд орчин үеийн, шинэ эм, бэлдмэлийг эмчилгээнд бүрэн нэвтрүүлж, хими эмчилгээний аюулгүй орчныг бэхжүүлэх

Хүрэх үр дүн:

Хими эмчилгээнд орчин үеийн шинэ эм, бэлдмэл эмчилгээнд нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжсэн байна.

Зорилт 4. Хөнгөвчлөх тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний бүх шатлалд сайжруулах, олон нийтэд түшиглэсэн тусlamж үйлчилгээг хөгжүүлсэнээр төгс эмчлэх боломжгүй хожуу үедээ илэрсэн хавдартай хүмүүсийг хөнгөвчлөх тусlamж, үйлчилгээнд хамруулж, амьдралын чанарыг сайжруулна.

Хүрэх үр дүн:

Аймаг, дүүргийн хавдрын тасагт хөнгөвчлөх эмчилгээний тогтмол ор ажиллах, гэрийн тусlamж, үйлчилгээ өргөжиж, өвдөлт намдаах эмээр тасралтгүй хангагдах, өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч наарт зориулсан тусlamж, үйлчилгээ бий болсон байна.

4.1 Олон нийтэд түшиглэсэн тусlamж үйлчилгээг хөгжүүлэх, гэрээр үзүүлэх тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

- Гэр бүл, асран хамгаалагч наарт зориулсан хөнгөвчлөх тусlamж үйлчилгээний гарын авлагыг боловсруулж, хэвлүүлэх, тэдэнд зориулсан сургалт явуулах,
- Хорт хавдрын хөнгөвчлөх, ялангуяа сэтгэл зүйн тусlamж үйлчилгээний удирдамжийг олон улсын жишгийн дагуу боловсруулж, мөрдөх
- Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг хүн амын тоо, өвчлөлийн түвшинд тохируулан хавдрын тасагт 5-аас доошгүй хөнгөвчлөх эмчилгээний ор ажиллуулах
- Нийт сум, өрхийн эмнэлгийг хөнгөвчлөх тусlamж үйлчилгээг гэрээр үзүүлэх чадвартай болгох
- ХСҮТ-ийн хөнгөвчлөх эмчилгээний тасгийг мэргэжил арга зүйн, сургалтын төв болгох
- Аймаг, дүүрэгт хөнгөвчлөх эмчилгээний мэргэшсэн эмч, сувилагч ажиллуулах, тасралтгүй сургах

- Аймаг, дүүргийн эмнэлгийг хөнгөвчлөх эмчилгээний шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах
- Эмч, мэргэжилтний зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах

4.2 Өвдөлт намдаах эмчилгээний менежментийг сайжруулж, опойд эмээр тасралтгүй хангаж, амьдралын чанарыг сайжруулна.

Үйл ажиллагааны чиглэл:

- Өвдөлт намдаах эмчилгээг ДЭМБ-ын удирдамжийн дагуу хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай эмийг тасралтгүй хангах,
- Өвдөлт намдаах эмчилгээний арга зүйд эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг сургах
- Өрх, сумын эмч, сувилагч нарыг хөнгөвчлөх эмчилгээний чиглэлээр тасралтгүй сургах ажлыг зохион байгуулах
- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний талаар тайлан, мэдээ, бүртгэлийг боловсронгуй болгох, мэдээний сан бий болгох

Зорилт 5:

Хавдрын тархварзүйн судалгааг хөгжүүлэх, эмнэлзүйн судалгааны ажлыг өргөжүүлэх, хорт хавдрын урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээний практикт судалгаа, шинжилгээний хамгийн сүүлийн үеийн үр дүн, сайн туршлагуудыг нэвтрүүлнэ.

Хүрэх үр дүн:

Хорт хавдрын молекул генетикийн судалгааны суурь тавигдсан байна. Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл болон генетикийн хамаарлыг харуулсан үндэсний хэмжээний лавлагаа мэдээллийн сантай болно.

Үйл ажиллагааны чиглэл

- Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл, шалтгаан механизмийг тодорхойлох болоод оношилгоо эмчилгээний шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр суурь судалгааг хийх үндэсний хэмжээний судалгааны төвийг ХСҮТ-ийн клиникийн эмнэлэг, бүртгэл мэдээллийн төвийг түшиглэн байгуулах,
- Хорт хавдрын чиглэлээр хийгдсэн суурь судалгааны үндэсний хэмжээний мэдээллийн сан бий болгох
- Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл, шалтгаан механизмиин талаар мэдлэг, нотолгоонд суурилсан мэдээллээр бодлого боловсруулагчид, холбогдох шатны байгууллага болон ард иргэдийг хангах
- Молекул биологийн судалгааны ажлын суурийг тавих
- Хорт хавдрын тархвар зүйн судалгааг хөгжүүлэх, эмнэлзүйн судалгааны ажлыг өргөжүүлэх

Зорилт 6.

Хүн амд суурилсан хорт хавдрын бүртгэл, тандалтын тогтолцоог бэхжүүлнэ.

Хүрэх үр дүн:

Хүн амд суурилсан хавдрын бүртгэлийн тогтолцоо бүрдэж, хорт хавдрын цахим мэдээний сантай болсон байна.

Үйл ажиллагааны чиглэл:

- Эмнэлэгт суурилсан хавдрын бүртгэл, мэдээллээс хүн амд суурилсан бүртгэл мэдээллийн тогтолцоонд бүрэн шилжих
- Хорт хавдраар өвчлөгсдийн хяналтын тогтолцоо бэхжүүлэх
- Хорт хавдрын тусlamж үйлчилгээний мэдээллийн цогц сан үүсгэж, цахим сүлжээгээр ашигладаг болсон байх
- Хорт хавдрын тандалтын тогтолцоог бэхжүүлэх
- Хорт хавдрын эмчилгээ, оношилгоо болон тусlamж, үйлчилгээг төлөвлөх, хорт хавдраас сэргийлэх, хянах бодлого боловсруулах үйл ажиллагааг нотолгоонд суурилсан чанартай мэдээллээр хангах

